



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 01499

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 34 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,531,959.8 /есөн сая таван зуун гучин нэгэн мянга есөн зуун тавин есөн төгрөг, наян мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 34 дүгээр цэцэрлэг /Л.Батхуяг/-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 9,531,959.8 /есөн сая таван зуун гучин нэгэн мянга есөн зуун тавин есөн төгрөг, наян мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 34 дүгээр цэцэрлэг /Л.Батхуяг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны .11. сарын
 25. өдрийн 8/479 дүгээр тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 34 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХК-н шийдвэр
1	Цэцэрлэгийн хашаа	64	м2	428	18,500.0	7,918,000.0	7,918,000.0	-	татах
Барилга байгууламжийн дүн				428		7,918,000.0	7,918,000.0	-	
2	Нэгдүгээр хоолны тогоо	64	ш	1	56,440.8	56,440.8	56,440.8	-	татах
3	Хоёрдугаар хоолны тогоо	64	ш	1	62,519.0	62,519.0	62,519.0	-	татах
4	Зөөврийн компьютер	5	ш	1	1,495,000.0	1,495,000.0	1,495,000.0	-	татах
Тоног төхөөрөмжийн дүн				3		1,613,959.84	1,613,959.84	-	
НИЙТ ДҮН				431		9,531,959.8	9,531,959.8	-	
Үүнээс : Худалдах хөрөнгө									
Устгах хөрөнгө									
Татан төвлөрүүлэх хөрөнгө						9,531,959.8	9,531,959.8	-	
Худалдсанаас олох орлого									
НӨАУГ-г төвлөрүүлэх /30%/									